



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 318

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 136,400,000.00 (нэг зуун гучин зургаан сая дөрвөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 128,443,333.24 (нэг зуун хорин найман сая дөрвөн зуун дөчин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд дарга А.Дагвадорж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Тамгын газрын дарга Ч.Энхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газрын нэр дээр бүртгэлтэй автомашины гэрчилгээ, улсын дугаарыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын нэр дээр шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН УҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

300559

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 2 дугаар сарын ...-ны өдрийн  
22 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖУЛЭХ АВТОМАШИН

Д/д	Автомашины марк, улсын дугаар, араг	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хууримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ланд крузер 200, 05-39 УНҮ, JTMН\051604107679	2013/2013	136,400,000.00	128,443,333.24	7,956,666.76
			136,400,000.00	128,443,333.24	7,956,666.76
	<b>Нийт дүн</b>	(нэг зуун гучин зураган сая дөрвөн зуун мянган)	(нэг зуун хорин найман сая дөрвөн зуун дөчин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин дөрвөн мянган)	(долоон сая есөн зуун тавин зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан зургаан мөнгө)	